

**ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ,  
ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ТАТАН ОРОЛЦУУЛАХ  
ПЛАТФОРМЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

---

**ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ,  
ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ТАТАН ОРОЛЦУУЛАХ  
ПЛАТФОРМ**

---

Судалгааны төрөл:

Харьцуулсан судалгаа

Судалгааны код:

СТ-25/255

Хугацаа:

2025.11.28

ЗАХИАЛАГЧ:

УИХ-ын гишүүн Ж.Золжаргал

Хянасан:

ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан:

Судалгааны хэлтсийн дарга Э.Дашзэгвэ

Судлаач:

Нийгмийн судалгааны хэсгийн референт Р.Оргилмаа

## АГУУЛГА

|                                                                                                                 |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| АГУУЛГА .....                                                                                                   | 2  |
| УДИРТГАЛ .....                                                                                                  | 3  |
| НЭГ. ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ПЛАТФОРМЫН<br>ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА ..... | 4  |
| 1.1. Иргэдийн оролцоо, зорилго, ач холбогдол .....                                                              | 4  |
| 1.2. Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах арга хэрэгслүүд .....                                        | 6  |
| ХОЁР. ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ПЛАТФОРМЫН ТУРШЛАГА .....                                                              | 8  |
| 2.1. Иргэдийн цахим оролцооны платформуудын зорилго, зарчим ба оролцооны<br>хэлбэрүүд .....                     | 8  |
| 2.2. Хэрэгжүүлэгч байгууллага, зохион байгуулалт .....                                                          | 14 |
| 2.3. Иргэдийн оролцооны үр дүн, нөлөөлөл, хүртээмжийн түвшин .....                                              | 16 |
| СУДАЛГААНЫ ҮР ДҮН .....                                                                                         | 22 |
| НОМ ЗҮЙ .....                                                                                                   | 24 |

## Хүснэгтийн жагсаалт

|                                                                               |    |
|-------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Иргэдийн оролцооны платформын хамрах хүрээ, үр дүн, нөлөөлөл ..... | 19 |
|-------------------------------------------------------------------------------|----|

## УДИРТГАЛ

“Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах платформ” харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах платформыг хөгжүүлэх ажлын хүрээнд жишиг платформыг санаачлан хэрэгжүүлж буй гадаадын улс орнуудын туршлагыг судлах.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгаанд Бразил Улс, Бүгд Найрамдах Исланд Улс (Исланд), Испанийн Хаант Улс (Испани), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (Энэтхэг)-ын үндэсний болон орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог дэмжих зорилго бүхий цахим платформын туршлага, үр дүнг авч үзэв. Улс орнуудын цахим оролцооны платформын зорилго, зарчим, оролцооны хэлбэрүүд, хэрэгжүүлэгч байгууллага болон иргэдийн оролцооны үр дүн, нөлөөлөл, хүртээмжийн түвшний талаар тус тус авч үзлээ. Мөн иргэдийн оролцооны платформын талаарх ойлголт, олон улсын чиг хандлага, платформын үүрэг, ач холбогдлын талаар тоймлон авч үзсэн болно.

**Судалгааны ажлын бүтэц:** Судалгаа дараах хэсэгтэй. Үүнд:

1. Иргэдийн оролцооны платформын үүрэг, ач холбогдол;
2. Олон улсын түвшинд иргэдийн оролцоог дэмжих бодлогын баримт бичиг, чиг хандлага, зарчмууд;
3. Платформын зорилго, зарчим, оролцооны хэлбэрүүд;
4. Хэрэгжүүлэгч байгууллага;
5. Иргэдийн оролцооны үр дүн, нөлөөлөл, хүртээмжийн түвшин.

**Судалгааны арга зүй:** Судалгааг удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

**Түлхүүр үг:** Орон нутгийн түвшний иргэдийн оролцооны платформ

**Key words:** Local level citizen engagement platform

## НЭГ. ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ПЛАТФОРМЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

### 1.1. Иргэдийн оролцооны зорилго, ач холбогдол

Иргэдийн оролцоо гэдэг нь иргэд, олон нийтийн төлөөлөл төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад өөрсдийн санал бодол, хүсэлтээ илэрхийлж, тодорхой хэмжээнд нөлөөлөх үйл явцыг хэлнэ. Ардчилсан нийгэмд оролцоо нь зөвхөн сонгуулиар хязгаарлагдахгүй бодлого боловсруулах үе шат болон нийтийн үйлчилгээ, түүнийг хүргэх бүхий л шат буюу “мэдээлэл түгээх, олон нийтээр зөвлөлдөх, хамтран шийдвэрлэх гэсэн оролцооны гурван тулгуур”-т арга зүйд үндэслэсэн иргэдийг оролцуулах бүх хэлбэрийг хамарсан ойлголт юм (OECD, 2022).

“Иргэдийн оролцоо” - г онолын түвшинд мөн дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

“Иргэдийн оролцоо гэдэг нь хувь хүн, бүлгүүд бүтээн байгуулалтын болон шийдвэр гаргах үйл явцад оролцож, хамтран ажиллахыг хэлнэ. Энэ нь зөвхөн оролцохоор хязгаарлагдахгүй, тухайн асуудлаар санал бодол, байр сууриа илэрхийлэх, шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагааг хамарна” (Nissen, 2021).

“Иргэдийн оролцоо гэдэг нь иргэд амьдралынхаа олон талбарт (ажлын байр, байгууллага, орон нутаг, улс төр) бодит шийдвэр гаргалтад оролцож, эрх мэдлийг хуваалцах, хянах үйл явцыг хэлнэ” (Carpentier, n.d.).

Улс төрийн оролцоо гэдэг нь төрийн албан тушаалтнуудыг сонгох, эсхүл тэдний гаргаж буй шийдвэр, арга хэмжээнд нөлөөлөх зорилготой, хувь иргэний үйлдлийг хэлнэ (Verba&Nie, 2016) гэж тус тус тодорхойлжээ.

Иргэдийн оролцооны гол зорилго нь иргэдийн санал хүсэлт, хэрэгцээг төрийн бодлогод тусгах, улмаар шийдвэр гаргалтыг ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй болгох юм. Нээлттэй засаглалын зарчмууд болох ил тод байдал, ёс зүй, хариуцлага, оролцоо нь үүний үндсэн тулгуур гэж үздэг байна.

Мөн иргэдийн оролцоог бодлогын мөчлөгт нийцүүлэх нь илүү чанартай, хүртээмжтэй, шударга шийдвэрт хүрэхэд чухал нөлөөтэй гэж үздэг (OECD, 2022). Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын 2024 онд дэлхийн 30 орныг хамруулсан “Итгэлд хөтлөгч хүчин зүйлс” судалгаагаар “төрийн шийдвэрт өөрийн саналыг нөлөөлөх боломжтой” гэж үздэг иргэдтэй улс орны үндэсний засгийн газартаа итгэх итгэл мэдэгдэхүйц өндөр байсан байна (OECD, 2024).

#### **Оролцооны түвшин, хэлбэрүүд**

ЭЗХАХБ-аас боловсруулсан “Иргэдийн оролцооны үйл явцын удирдамж”-д иргэдийн оролцооны 8 арга, хэлбэр, хэрэгжүүлэх 10 алхмыг тус тус дараах байдлаар тодорхойлсон байна (OECD, 2022). Үүнд: Арга, хэлбэрүүдэд дараах зүйлсийг багтаана:

- мэдээлэл ба өгөгдөл (иргэдийг мэдээллээр хангах);
- нээлттэй уулзалт;

- олон нийтийн зөвлөлдөх ажиллагаа (санал авах, хэлэлцүүлэх);
- нээлттэй инновац (хамтран шийдэл олох);
- иргэдийн оролцоот судалгаа (citizen science);
- иргэний хяналт;
- иргэдийн оролцоотой төсөвлөлт;
- төлөөллийн хэлэлцүүлэг (иргэд төлөөллөөрөө бодлого боловсруулах, шийдвэрт оролцох) зэрэг орно.

Тус баримт бичигт иргэдийн оролцоо нь үнэ цэнтэй төдийгүй хэрэглээний хувьд ач холбогдолтой, эцсийн дүндээ бодлого, шийдвэрийг илүү ил тод, хүртээмжтэй, хууль ёсны, хариуцлагатай болгосноор төрийн байгууллагад иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх үр дүнтэй болохыг онцолжээ.

### **Олон улсын чиг хандлага зарчим**

Олон улсын байгууллагууд засаглал дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь ардчиллыг бэхжүүлэх гол нөхцөл гэж үздэг бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичгүүдэд иргэдийн оролцоог дэмжих зарчмуудыг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал,

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ)-ын 16.7-д “шийдвэр гаргалтыг бүх түвшинд хариу үйлдэлтэй, хүртээмжтэй, иргэдийн өргөн оролцоотой, төлөөллийн шинжтэй болгох”-ыг улс орнуудад зорилт болгон дэвшүүлсэн (UN, 2025).

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) ч мөн “хэнийг ч үл орхигдуулах” (leave no one behind) зарчмын хүрээнд бодлого боловсруулахад эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цөөнхийн бүлгүүдийн идэвхтэй оролцоог хангахыг зөвлөн, оролцооны орон зайг ийнхүү өргөжүүлэн, иргэдэд бодлого тодорхойлох үйл явцад шууд оролцох боломж олгох нь хүртээмжтэй, хариу үйлдэлтэй засаглалыг бүрдүүлэх гол хүчин зүйл болохыг онцолдог байна (UNDP, 2018).

Дэлхийн Банкны иргэний оролцоог дэмжих стратегид “иргэд нь төрийн байгууллагыг ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, хөгжлийн сорилтуудад шинэлэг шийдэл гаргахад хувь нэмэр оруулдаг” гэж тодорхойлсон байна (World Bank Group, 2025). Иргэдийн бодит оролцоо нь засаглалыг бэхжүүлж, иргэдийг чадавхжуулан, төр-иргэний харилцааг сайжруулж, нийтийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлдэг нь судалгаагаар нотлогджээ (World Bank, 2013).

Дэлхийн Банк “Иргэдийн оролцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэх стратеги” баримт бичгийг 2014 онд батлан, дараах таван үндсэн зарчмыг дэвшүүлсэн байна (NDC Partnership, n.d.). Үүнд:

- 1) үр дүнд чиглэсэн байх
- 2) үйл ажиллагааны бүх үе шатанд оролцоог хангах
- 3) улс орны өөрийн тогтолцоог бэхжүүлэх
- 4) тухайн орчны онцлогт нийцүүлэх
- 5) үе шаттай тасралтгүй хэрэгжүүлэх зэрэг болно.

Эдгээр зарчим нь иргэдийн оролцоог бодлого, төсөл хөтөлбөрийн бүх түвшинд төлөвшүүлэх замаар төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж, эцсийн дүндээ ядуурлыг бууруулах, хамтын хөгжлийг ахиулахад чиглэдэг байна.

## **1.2. Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах цахим арга хэрэгслүүд**

Орчин үед иргэдийн оролцооны хамгийн үр дүнтэй, шуурхай, хялбар арга хэрэгсэл нь цахим оролцооны арга болж байна. НҮБ-аас “цахим оролцоо” гэдэг нь төрөөс мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сувгуудаар иргэдэд мэдээлэл өгөх (e-information), олон нийтийн зөвлөлдөх ажиллагаа явуулах (e-consultation), иргэдийн оролцоотой шийдвэр гаргах (e-decision-making) замаар бодлогын мөчлөгт иргэдийг татан оролцуулах үйл явцыг хэлнэ гэж тодорхойлсон (UN, 2024).

НҮБ-ын 2024 онд 193 гишүүн орноо хамруулан хийсэн, ээлжит “Цахим засаглалын судалгаа”-д улс орнуудад иргэдийн цахим оролцоо өргөжиж, олон сувагт шийдэл давамгайлж буйг онцолсон байна. Тус судалгаанд цахим засаглалын хөгжлийн индекс сүүлийн хориод жил тогтвортой өсч, цахим засаглалын бодлого, хэрэгжүүлэх байгууллага, үйлчилгээ, өгөгдөл, цахим орчин зэрэг хэмжээсийг уялдуулсан “Цахим засаглалын загвар хүрээ”-г танилцуулан, цахим оролцоог (e-information, e-consultation, e-decision-making зэрэг) илүү өргөн хүрээнд, институцийн үйл явцтай цогцоор нь холбох шаардлагыг тодруулжээ (UN, 2024). Орон нутгийн түвшинд цахимжуулалт эрчимжиж, олон улс орнууд нэг цонхны портал ба олон сувагт (вэб-портал, мобайл апп, дуудлагын төв зэргийг уялдуулсан) үйлчилгээний загварыг нэвтрүүлж байгаа ч дэд бүтэц, эрх зүй, хүний нөөцийн чадавхын ялгаатай байдал хэвээр байгааг тэмдэглэсэн байна.

Нээлттэй засаглалын үзэл баримтлалд иргэдийн оролцоог ардчилсан засаглалын чанарыг сайжруулах, итгэлцлийг нэмэх гол хөдөлгүүр хэмээн тунхаглаж (OECD, 2025), ялангуяа орон нутгийн түвшинд иргэдийн шууд оролцоо, санал, санаачилга нь үндэсний түвшнээс илүү үр дүнтэй болохыг ЭЗХАХБ-ын төлөөллийн хэлэлцүүлгийн эмпирик судалгаагаар баталгаажуулсан байна (OECD, 2020). ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын иргэдийн 41% нь өөрийн орон нутагт хамааралтай шийдвэрт нөлөөлөх боломжтой гэж үзсэн нь улсын хэмжээнд бодлого боловсруулахад нөлөөлөх итгэлээс харьцангуй өндөр үзүүлэлттэй байсан байна (OECD, 2021). Иймээс олон улсын түвшинд орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог хангах шинэлэг арга хэрэгслүүдийг хөгжүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах нь ардчиллыг бэхжүүлэх нийтлэг чиг хандлага болоод байна.

Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд иргэдийн оролцоог хангах уламжлалт институцийн механизм болон шинэлэг цахим шийдлүүдийг хослуулан, бодлого боловсруулах бүх үе шатанд системтэй холбох чиг хандлага давамгайлж байна. Ингэснээр оролцоо нь зөвхөн мэдээлэл солилцоогоор хязгаарлагдахгүй, харин бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-үнэлгээний үе шаттай тасралтгүй уялдах нөхцөл бүрдэнэ. ЭЗХАХБ-ын “Иргэдийн оролцооны үйл явцын удирдамж” нь институцийн ба цахим хэрэгслийг уялдуулах суурь лавлагаа болдог байна.

Институцийн арга хэмжээнд орон нутгийн түвшний иргэдийн нийтийн хурал, орон нутгийн зөвлөл, олон нийтийн сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, хороо, багийн

иргэдтэй уулзалт хийх, төсөв, төлөвлөлтийн асуудлаар санал авах зөвлөлдөх уулзалтууд, иргэний танхимын уулзалтууд зэргийг дурдаж болно. Тухайлбал, зарим улсад орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэхдээ иргэдийн оролцооны зөвлөл байгуулан, иргэдийн саналыг албан ёсоор нэгтгэн тусгах тогтолцоотой. Мөн олон нийтийн төлөөллийг оролцуулсан байнгын хороод, зөвлөлүүд ажиллаж, тодорхой асуудлаар иргэдийн санал, дуу хоолойг шийдвэр гаргагчдад хүргэх боломжийг бүрдүүлдэг.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар иргэдийн цахим оролцоо хурдацтай өргөжин, дэлхийн олон улс орон цахим оролцооны платформуудыг төрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, иргэдтэй харилцах албан ёсны сувгуудыг бий болгож байна. Цахим оролцооны нэг хэлбэр болох цахим хэлэлцүүлэг, цахим санал асуулга зэрэг нь бодлогын зөвлөлдөх үйл явцын түгээмэл хэлбэр болж, олон тулгамдсан асуудлыг цахимаар иргэдийн оролцоотойгоор хэлэлцэн, шийдвэрлэдэг болсон. Цахим оролцоо нь өргөн хүрээний, хүртээмжтэй оролцоог хангах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ цаг хугацаа, орон зайн хязгаарлалтаас үл хамааран иргэд өөрсдийн санал бодлыг илэрхийлж, бодлого шийдвэрт нөлөөлөх боломжийг бүрдүүлж байна. Улс орнуудын туршлагаас дурдвал, төрийн албан ёсны цахим хуудаснуудаар дамжуулан хууль, бодлогын баримт бичгийн төслүүдэд олон нийтийн санал авах, цахим санал асуулга явуулах, өргөдөл хүлээн авах тусгай веб хуудас ажиллуулах, иргэдээс хэрэгцээтэй мэдээлэл, санал хүсэлтийг нь хүлээн авах аппликэйшн боловсруулах зэрэг олон шийдлийг ашиглаж байна. Орон нутгийн түвшинд хот, орон нутгийн төсөвт санал өгөх, хотын үйлчилгээтэй холбоотой гомдол мэдээлэх систем, хотын газрын зурагт асуудал байршуулах портал зэрэг шинэлэг шийдлүүдийг тус тус нэвтрүүлж байна.



## ХОЁР. ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ПЛАТФОРМЫН ТУРШЛАГА

Судалгааны энэ хэсэгт Бразил Улс, Бүгд Найрамдах Исланд Улс (Исланд), Испанийн Хаант Улс (Испани), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (Энэтхэг)-ын үндэсний болон орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог дэмжих зорилго бүхий цахим платформын туршлага, үр дүнг авч үзлээ. Эдгээр платформуудын нийтлэг зорилго нь иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлж, тэдний санал санаачилгыг бодлого, шийдвэрт тусгах замаар засаглалын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах явдал юм.

### 2.1. Иргэдийн цахим оролцооны платформуудын зорилго, зарчим ба оролцооны хэлбэрүүд

**Бразил Улсад** иргэдийн оролцоог цахим хэлбэрээр дэмжих бодлого 2010 оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд үүний анхны томоохон туршилт нь “Participa.br” платформ байв. Тус платформыг 2014 онд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд санаачлан бүтээсэн бөгөөд төрийн бодлого боловсруулах үйл явцад иргэдийн саналыг өргөнөөр тусгах зорилготой байв. Өмнө нь тусдаа ажиллаж байсан “Governo Eletrônico”, “E-Democracia” зэрэг цахим оролцооны сувгуудыг нэгтгэн “Participa.br” нэгдсэн системийг бүтээсэн байна (Beatriz & Lisboa, 2020).

Энэхүү санаачилга нь үндэсний түвшинд хэрэгжсэн анхны иж бүрэн цахим оролцооны систем бөгөөд төрийн бүх яам, агентлагууд, иргэний нийгмийн байгууллагууд болон нийт иргэдийг холбосон нээлттэй, олон түвшний оролцооны дэд бүтэц байв. Үндсэн зорилго нь иргэдийн саналыг бодлого, хууль тогтоомжийн хэлэлцүүлэгт албан ёсоор тусгах, иргэдийн дуу хоолойг төрийн шийдвэр гаргалтад хүргэх явдал юм.

Бразил Улс иргэдийн оролцоог шинэ шатанд гаргах зорилгоор 2023 онд “Brasil Participativo” хэмээх платформыг нэвтрүүлсэн (Open Government Partnership, 2024). Энэхүү санаачилгыг тус улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяан дахь Нийгмийн оролцооны үндэсний удирдах газар (National Secretariat for Social Participation) хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд платформыг “Холбооны түвшний бодлого боловсруулах үйл явцад иргэдийг өргөнөөр татан оролцуулах төвлөрсөн, тогтвортой, орчин үеийн цахим суваг” гэж тодорхойлсон байна (Presidency of the Republic, 2024). “Brasil Participativo” нь өмнөх “Participa.br”-ийн туршлагад үндэслэн, технологийн хувьд нээлттэй эхийн “Decidim” программын хүрээнд хөгжүүлсэн бөгөөд оролцооны уламжлалт хэлбэрүүдийг цахим орчинтой нэгтгэн ажиллахаар бүтээгджээ.

“Brasil Participativo” нь иргэдэд дараах боломжуудыг олгодог (Gov.br, 2025). Үүнд:

- Онлайн хэлэлцүүлэг (online consultations), санал хураалт – эрүүл мэнд, байгаль орчин, дэд бүтэц зэрэг салбаруудын бодлогын асуудлаар санал өгөх, хэлэлцэх;
- Олон нийтэд зориулсан дижитал үйл ажиллагаа (open digital participatory processes) – төрөөс санаачилсан эсвэл иргэдийн хүсэлтээр нээлттэй хэлэлцүүлэгт оролцох, саналаа илгээх, иргэдийн бичсэн санал, санаачилгыг дэмжих, эсвэл няцаах;
- Оффлайн үйл ажиллагаанд бүртгүүлэх ба мэдээлэл авах – орон нутгийн уулзалт, чуулга уулзалтад оролцох сонирхолтой иргэдийг бүртгэх;

- Цахим уулзалт, төлөөлөгч сонгох механизм – цахим хэлэлцүүлгийн үр дүнд тодорхой иргэд төлөөлөгчөөр сонгогдон үндэсний хэмжээний чуулган болон бодлогын зөвлөлдөх хуралд оролцох боломжтой.

Платформын уян хатан бүтэц нь оролцооны хэлбэрийг тухайн хэлэлцүүлэг, санал асуулгыг зохион байгуулж буй төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад өөрсдийн хэрэгцээнд тохируулан төлөвлөх боломжийг олгодог бөгөөд зарим тохиолдолд цахимаар сонгогдсон төлөөлөгчид тухайн арга хэмжээнд цахимаар, эсвэл биечлэн оролцох нөхцөлийг бүрдүүлдэг байна (Democracy technologies, 2023).

**Исланд Улсын** нийслэл Рейкьявик хотод 2010 оноос “Better Reykjavík” цахим оролцооны платформыг хэрэгжүүлж байна (Better Reykjavík , 2025). Дэлхийн 45 улсад цахим ардчиллын нээлттэй эхийн шийдэл хэрэгжүүлдэг “Citizens Foundation” ашгийн бус байгууллага Рейкьявик хотын захиргаатай хамтран тус платформыг боловсруулж, хэрэгжүүлжээ (OECD, Observatory of Public Sector Innovation, 2010). Тус платформ нь иргэдийн оролцоонд тулгуурласан хамтын бүтээмжийн (co-creation) хэлбэрийг хөгжүүлэх, хотын тулгамдсан асуудлуудад олон нийтийн саналыг авч, хэлэлцүүлгийг бодит шийдвэр гаргалттай уялдуулах үндсэн зорилготой.

“Better Reykjavík” нь иргэдийн оролцоог гурван үндсэн чиглэлээр зохион байгуулдаг (OECD, Observatory of Public Sector Innovation, 2010):

1. Асуудал танилцуулан, хэлэлцэх (Agenda Setting): Иргэд тулгамдсан асуудал, шинэ санаагаа цахимаар илгээж, бусад иргэдээс санал, дэмжлэг авах;
2. Оролцоот төсөвлөлтөд санал өгөх (Participatory Budgeting): Хотын төсвийн тодорхой хэсэгт иргэд саналаа өгч, цахим хэлэлцүүлэг болон санал хураалтаар тэргүүлэх саналыг сонгох;
3. Бодлого боловсруулах (Policy Crowdsourcing): Тодорхой салбарын бодлогын талаар санал цуглуулж, хэлэлцэх зэрэг орно.

Эдгээр чиглэлүүд нь хотын иргэдийн санаачилгыг ил тод, хяналттайгаар боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх гурван үе шат бүхий тасралтгүй оролцооны механизмыг бүрдүүлсэн байна.

Тус платформд иргэд өөрсдийн саналыг ямар ч сэдвээр оруулж болох бөгөөд бусад иргэд тухайн саналын давуу ба сул талын талаар мэтгэлцэн, санал нэмэх, мөн дэмжих эсвэл эсэргүүцэх боломжтой (Citizens.is, 2025). Мэтгэлцээний энэ бүтэц нь жирийн “сэтгэгдэл бичих” хэлбэрээс ялгаатай бөгөөд иргэдийг баримт, үндэслэлд тулгуурласан маргааны соёлд сургах, олон нийтийн хэлэлцүүлгийг илүү бүтээлч, бодитой болгох ач холбогдолтой гэж судлаачид дүгнэсэн байна (OECD, Observatory of Public Sector Innovation, 2010). Иргэдийн оруулсан санал бүр хотын захиргаанд эрэмбэлэгдсэн, үнэлгээтэй хэлбэрээр хүрдэг тул шийдвэр гаргагчид хамгийн их дэмжлэг авсан саналуудыг бодлого, хөрөнгө оруулалтын төлөвлөлтдөө тусгах боломжтой (NESTA, n.d.).

#### “Миний амьдрах орчин” оролцооны төсвийн хөтөлбөр

Рейкьявик хотын захиргаа 2011 оноос 2 жил тутам “Better Reykjavík” платформоор дамжуулан “Миний амьдрах орчин” (Better Neighborhoods) оролцооны төсвийн хөтөлбөрийг

хэрэгжүүлж иржээ (Reykjavik, 2023). Тус хөтөлбөрөөр хотын хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг иргэдийн санал асуулгаар хуваарилдаг байна. Иргэд гурван долоо хоногийн хугацаанд цахимаар санал ирүүлж, мэргэжлийн багууд болон Рейкьявик хотын хорооллын зөвлөлүүд хамтран, хэрэгжих боломжтой саналуудыг шалгаруулдаг байна. Эцсийн шатанд иргэд дэмжсэн төсөлдөө цахимаар санал өгч, хамгийн их дэмжлэг авсан, тэргүүлэх төслүүд тухайн жилийн хотын төсөвт тусгагдан хэрэгждэг (Citizens.is, 2025). Санал асуулгад хотын хүн амын ойролцоогоор 12–13% нь шууд оролцдог байна.

“Better Reykjavík” нээлттэй байдлаараа 120 мянган хүн амтай Рейкьявик хотын иргэдийн тал хувийг хамарсан амжилттай жишээ болсон бөгөөд 2010 оноос хойш 700 орчим санал, санаачилга бодитоор хэрэгжсэн байна (OECD, Observatory of Public Sector Innovation, 2025). Иргэдийн эдгээр санал, санаачилга нь (тухайлбал, цэцэрлэгт хүрээлэнд хүүхдийн тоглоомын талбай нэмэх, дугуйн зам шинээр тавих, номын сангийн ажлын цагийг сунгах зэрэг) хотын дэд бүтэц, нийтийн орон зайн хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг байна.

“Better Reykjavík” нь цөөн хүн амтай улсад цахим ардчиллыг амжилттай хэрэгжүүлэх боломжийг харуулсан шинэлэг загвар болж, олон улсын түвшинд өндөр үнэлэгдсэн. “Citizens Foundation”-ийн боловсруулсан “Your Priorities” нээлттэй эхийн программыг Исланд болон олон улсад бодлогын зөвлөлдөх, төсвийн оролцооны төсөлд өргөнөөр ашиглаж байна (Citizens.is, 2025).

**Испани Улсын** орон нутгийн түвшинд цахим ардчиллын амжилттай хэрэгжсэн жишээ бол Мадрид хотын захиргаанаас 2015 онд нэвтрүүлсэн “Decide Madrid” платформ юм. Тус платформ нь нээлттэй засаглалын албан ёсны цахим талбар бөгөөд иргэдэд хотын бодлого, шийдвэрт шууд оролцох нэг цэгийн оролцооны систем бүхий орчныг бий болгосон. Платформ нь “CONSUL” нээлттэй эхийн программ дээр суурилсан бөгөөд Мадрид хотын захиргаа хөгжүүлэлт, хэрэгжилтийг хариуцдаг.

Цахим оролцооны дараагийн том загвар болсон “Decidim.barcelona” платформыг 2016 онд Барселона хотын захиргаанаас санаачлан хэрэгжүүлж эхэлсэн байна (Barcelona, 2025). “Decidim” (Каталон хэлээр “Бид шийднэ”) нь мөн нээлттэй эхийн программ хангамж бөгөөд анх Барселона хотын 2016–2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах зорилгоор ашиглаж эхэлжээ. Платформын программ хангамжийг “CONSUL” нээлттэй эхийн программ дээр суурилан, сайжруулж бүтээсэн байна. Харин 2017 онд тус платформыг бүрэн дахин бичиж, Барселонаас гадна бусад хот, байгууллагууд ашиглах боломжтой нээлттэй эхийн хүрээ (framework) болгон хөгжүүлжээ. “Decidim” платформын хөгжил, түгээлтийг Барселона хотын захиргаанаас санхүүжүүлж эхэлсэн бөгөөд өдгөө олон улс оронд олон хот, байгууллага иргэдийн цахим оролцооны порталд энэхүү программыг ашиглах болсон байна. “Decidim” платформын үндсэн хөгжүүлэлт, засвар сайжруулалтыг хангах зорилгоор “Decidim сан” ашгийн бус холбоо байгуулсан байна. Тус сан нь платформыг зөвхөн нэг хотын хэмжээнд бус, иргэдийн нээлттэй оролцоог дэмжсэн олон улсын хөдөлгөөн болгон өргөжүүлэн удирдаж байна.

“Decidim” нь иргэдийн онлайн болон оффлайн оролцоог уялдуулсан, ил тод, нээлттэй оролцооны систем бөгөөд дараах үндсэн хэлбэрүүдтэй (UN, Department of Economic and Social Affairs, n.d.). Үүнд:

- Оролцооны үйл явц (Processes) – “Decidim” нь тодорхой хугацаанд үргэлжлэх төсөл, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө, хот төлөвлөлтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах “оролцооны үйл явц” хэсэгтэй. Энд нээгдсэн процесс бүр дээр иргэд өөрийн шинэ санал оруулах, бусдын саналыг уншиж сэтгэгдэл бичих, саналыг дэмжих эсвэл няцаах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой. Иргэд өөрийн оруулсан саналаа сошиал сүлжээгээр түгээж, бусдаас дэмжлэг хүсэх боломжтой. Энэ нь оролцооны хүрээг тэлдэг байна.
- Иргэдийн санал, санаачилга (Citizen initiatives) – “Decidim” нь иргэд саналаа илгээх тусгай модультай. Иргэд тодорхой асуудлаар санал дэвшүүлж, саналыг дэмжих цахим гарын үсэг цуглуулна. Шаардагдах тооны дэмжлэг (тухайлбал, хүн амын 1%-ийн квот) авсан тохиолдолд тухайн саналыг хотын удирдлага заавал хэлэлцэх үүрэгтэй. Ийм санал нь хөршийн зөвлөл байгуулах, нийтийн сонсгол зарлах, хотын дүрэм журмыг шинэчлэх зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарч болох бөгөөд “Decidim” дээр эхлээд бүртгэгдэж, техникийн хяналт, эрх зүйн шалгалтаар орсны дараа олон нийтийн дэмжлэг цуглуулах шат руу ордог.
- Хэлэлцүүлэг (Debates) – Платформын хэлэлцүүлэг хэсгээр дамжуулан иргэд тодорхой асуудлаар онлайн мэтгэлцээн өрнүүлж, саналыг зөвхөн “дэмжсэн/дэмжээгүй” түвшинд бус баримт, үндэслэл бүхий байр суурь, тайлбартай мэтгэлцээн өрнүүлэх боломжтой. Ингэснээр “Decidim” нь саналын “тоо”-оос гадна саналын “чанар, үндэслэл”-ийг харгалзан үзсэн хэлэлцүүлгийн соёлыг дэмждэг байна.
- Онлайн ба оффлайн оролцоог нэгтгэх – “Decidim” платформ дээр зөвхөн цахимаар гарсан санал бус, хурал, уулзалт зэрэг иргэд биечлэн оролцсон хэлэлцүүлгээс гарсан саналуудыг давхар бүртгэн оруулдаг байна. Өөрөөр хэлбэл, иргэд биечлэн оролцсон уулзалтуудын тэмдэглэл, дэвшүүлсэн саналууд, тэдгээрийн үр дүнг платформд системтэйгээр оруулснаар онлайн болон оффлайн оролцоо нэг процессын хүрээнд уялдаа холбоотой явагддаг.
- Оролцоот төсөвлөлт (Participatory budgeting) – Барселона хот анхны том хэмжээний хөрөнгө оруулалтын хэлэлцүүлгийн үйл ажиллагааг 2020–2021 онд “Decidim”-ээр зохион байгуулсан байна. Иргэд цахимаар төсвийн төслүүдийг санал болгож, тодорхой дэмжлэгт хүрсэн саналуудыг мэргэжлийн баг техникийн болон санхүүгийн боломжийг нь судлан, бодит төсөл болгон боловсруулсан. Иргэд дэмжиж буй төсөлдөө цахимаар санал өгсөн бөгөөд хамгийн их дэмжлэг авсан төслүүдийг шийдвэрлэсэн байна. Ингэснээр хотын хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг иргэд өөрсдөө эрэмбэлэх оролцооны механизм бүрджээ.
- Иргэдийн оролцооны зөвлөлүүдийн хурал, хэлэлцэх асуудал, тэмдэглэлүүдийг ил тод байршуулах – “Decidim” нь зөвхөн цахимаар дамжих оролцоо бус, орон нутгийн байнгын зөвлөл, хороо зэрэг байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох хэрэгсэл болж ашиглагддаг. Барселона хотын олон салбарын Иргэдийн оролцооны зөвлөлүүдийн хурал, хэлэлцэх асуудал, хурлын тэмдэглэл зэрэг мэдээллийг “decidim.barcelona” вэбсайтад байршуулдаг бөгөөд иргэд эдгээрийг чөлөөтэй уншиж

танилцахын зэрэгцээ зарим нээлттэй хуралд цахимаар бүртгүүлэн оролцох боломжтой байна.

“Decidim.barcelona” оролцооны платформ нь богино хугацаанд олон мянган иргэнд хүрч, 10 мянга гаруй санал хүлээн авч, 400 орчим нүүр тулсан уулзалт, 160 мянга гаруй дэмжсэн санал цуглуулсан нь Барселонагийн бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоо нь байгууллагатай уялдсан тогтолцоо болж хөгжсөнийг харуулж байна (decidim docs, n.d.).

Нээлттэй эхэд суурилсан “Decidim” программ нь Европ, Америк тивийн 40 гаруй хот, бүс нутагт ашиглагдаж байгаа бөгөөд Франц, Итали, Финланд, Португал, Мексик зэрэг улс орнууд өөрсдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хэрэглэж байна (UN, Department of Economic and Social Affairs, n.d.).

Онлайн ба оффлайн оролцоог хослуулсан, модульт бүтэцтэй загвар нь цахим ардчиллын “шинэлэг сайн туршлага” хэмээн олон улсын байгууллагуудаар үнэлэгдэж, оролцооны төсөв, бодлого боловсруулах, дүрэм журам шинэчлэх зэрэг өргөн хүрээнд ашиглагдаж байна (IDS, 2023).

**Энэтхэг Улсын** Засгийн газар 2014 онд үндэсний хэмжээний иргэдийн оролцооны нэгдсэн “MyGov” платформыг нэвтрүүлсэн байна. Платформын гол зорилго нь иргэдийг бодлого, шийдвэр гаргах үйл явцад өргөнөөр оролцуулж, сайн засаглалыг төлөвшүүлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шатанд олон нийтийн санал, санаачилгыг системтэй тусгахад оршино (Impact and Policy Research Institute, 2025).

“MyGov” платформ нь зөвхөн мэдээлэл түгээх нэг талын суваг бус, харин иргэд төдийгүй хувийн хэвшил, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллагуудаас санал, шүүмж, санаачилга, бүтээлч шийдлийг цахим орчинд олон нийтийн оролцоонд тулгуурлан цуглуулж, шүүн эрэмбэлэх (crowdsourcing) замаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад инновац нэвтрүүлэх орчин үеийн оролцооны механизм гэж үнэлэгддэг байна.

“MyGov” платформ нь тус бүр өөр үүрэгтэй, олон хэсгээс бүрдсэн “модуль” бүтэцтэй бөгөөд иргэдийн оролцоог олон хэлбэрээр зохион байгуулахад чиглэсэн байна. Үүнд:

- Бүлгүүд (Groups) – Тодорхой сэдэв, салбар (эрүүл мэнд, боловсрол, цахим засаглал, байгаль орчин зэрэг)-тай холбоотой бүлгүүдэд иргэд нэгдэж, тухайн асуудлаар өрнөж буй хэлэлцүүлэг, санал асуулга, даалгаварт оролцоно;
- Хэлэлцэх (Discuss) – Яам, агентлагууд бодлогын тодорхой сэдвээр нээлттэй форум хэлбэрийн хэлэлцүүлэг нээж, иргэд сэтгэгдэл хэлбэрээр санал бодлоо бичиж, харилцан мэтгэлцэнэ;
- Даалгавар гүйцэтгэх (Do, Tasks) – Иргэд сайн дурын ажил болон тодорхой даалгаварт (тухайлбал, “ой мод тарих”, “ус хэмнэлтийн туршилт хийх” гэх мэт) бүртгүүлж, гүйцэтгэлийн тайлан, баримтаа платформд байршуулах боломжтой;
- Санал асуулга, судалгаа (Poll, Survey) – Төрийн байгууллагууд тодорхой шийдвэр гаргахын өмнө болон дараа нь олон нийтийн санал бодлыг тандах зорилгоор богино асуулга явуулдаг;

- Онлайн уулзалт, вебинар (Talk) – Хариуцсан сайд, албан тушаалтан, экспертүүд иргэдтэй шууд харилцах уулзалт, вебинар, онлайн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг.
- Шинэлэг шийдлийн уралдаан, Бүтээлч булан (Innovation Challenges / Creative Corner) – Төрийн байгууллагууд, тэдгээрээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хүрээнд бүтээлч контентын уралдаан өрнүүлж, иргэдийн санал, бүтээлийг “crowdsourcing” хэлбэрээр ашигладаг.
- Мэдлэг шалгах сорил болон Дэмжлэгээ илэрхийлэх (Quiz, Pledge) – Иргэд тодорхой бодлого, кампанит ажлын талаар онлайн асуулт-хариултын сорилд оролцож, аливаа үйл ажиллагааг (тухайлбал, цэвэр орчин, жендэрийн тэгш байдал, замын аюулгүй байдал гэх мэт) дэмжиж, дэмжлэгээ илэрхийлдэг байна.

Эдгээр олон хэлбэрүүд нь иргэд зөвхөн үзэл бодлоо илэрхийлээд зогсохгүй, бодит ажилд гар бие оролцох, эсвэл мэдлэг, ур чадвараа хуваалцах түвшний оролцоог ч дэмждэг байна. “MyGov” платформ дээр аливаа хэлэлцүүлэг, санал асуулгыг ихэвчлэн тодорхой хугацаатай нээж, дууссаны дараа түүнийг нэгтгэн дүгнэж, хариу мэдээлэл оруулдаг дараалсан шатлалтай. Ингэснээр иргэд өөрийн гаргасан саналын талаар мэдээлэл авах нөхцөл бүрддэг. “MyGov” платформ нь оролцоог тогтвортой хадгалах, хэрэглэгчдийн идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор сэдэлжүүлэх шаталсан элементүүдийг ашигладаг. Тухайлбал, хэрэглэгчдийн идэвхээс хамааран оноо, түвшин, “MyGov Saathi” буюу “Засаглалын хамтрагч” гэсэн зэрэглэл олгох зэрэг урамшууллын систем нэвтрүүлж, тодорхой хэмжээний оноо цуглуулсан хэрэглэгчдэд өргөмжлөл, сертификат, зарим тохиолдолд урамшуулал олгох боломжтой байна (Educate Bee, 2023).

Түүнчлэн “Шинэлэг шийдлийн уралдаан” (Innovation Challenges), “Бүтээлч булан” (Creative Corner) зэрэг дэд платформуудаар дамжуулан төрийн томоохон кампанит ажлын лого, уриа лоозон, нэр томьёог иргэдийн дунд уралдаантайгаар сонгон шалгаруулж, тухайн хөтөлбөрийн “брэнд”-ийг олон нийтийн санал дээр тулгуурлан бүрдүүлэхийг зорьдог байна. Энэ нь нэг талаас төсвийн зардлыг бууруулах, нөгөө талаас иргэдийн санал үнэлэмж нь улс төр-засаглалын илэрхийлэл болж байгааг тэдэнд мэдрүүлэх замаар олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх ач холбогдолтой гэж үзсэн байна (IMPRI, 2025).

Эдгээр модулиудын нийлбэр нь MyGov-ийг зөвхөн санал асуулгын сайт биш, харин бодлого хэлэлцэх, сайн дурын ажил, тэмцээн уралдаан, боловсролын контент, мэдээлэл цуглуулах кампанит ажил зэрэг олон түвшний оролцоог нэг дор нэгтгэсэн “цогц оролцооны экосистем” болгодог байна (IGI Global, 2020).

Судалгаанд авсан улс орнуудын иргэдийн оролцооны платформын нийтлэг зарчим нь иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлж, тэдний санал бодлыг бодлого, шийдвэр гаргах үйл явцад системтэй тусгах замаар засаглалын ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чиглэж байна. Бразилын “Brasil Participativo”, Испанийн “Decidim.barcelona” платформууд нь ялангуяа шууд ардчиллын хэрэгслүүд болох иргэдийн санал, санаачилга, оролцооны төсөв, албан ёсны цахим санал хураалтын механизмыг онцгой хөгжүүлсэн бөгөөд тодорхой босго (хүн амын хувь, саналын тоо) хангасан саналыг заавал хэлэлцэх, бүх нийтийн санал хураалтад оруулах эрх зүйн механизмыг бүрдүүлсэн байна. Харин Исландын “Better Reykjavík”, Энэтхэгийн “MyGov” платформууд нь оролцооны хэлбэрийн цар хүрээг илүү өргөн авч үзэж, асуудал дэвшүүлэх, бодлого хэлэлцэх, оролцоот төсөвлөлт, сайн дурын ажил, мэдлэг шалгах сорил, уралдаан, мэдээллийн кампанит ажил зэрэг олон түвшний,

олон төрлийн оролцоог нэг дор нэгтгэсэн “экосистем” хэлбэртэй хөгжсөн нь онцлогтой байна.

Технологийн шийдлийн хувьд Испани, Исланд улс нь нээлттэй эхийн программ хангамж (Consul, Decidim, Your Priorities зэрэг) ашигласнаар хотууд хоорондоо код, загвар, аргачлалаа хуваалцаж, тухайн нөхцөлдөө тохируулан өөрчлөн, сайжруулах “сүлжээний” хөгжлийг бий болгосон бол Бразил, Энэтхэг улсын хувьд төв засгийн газрын төвлөрсөн удирдлага, санхүүгийн дэмжлэгтэй, үндэсний хэмжээнд нэгтгэсэн дэд бүтцэд суурилсан платформуудыг хөгжүүлсэн байна. Эдгээр платформын онцлог нь уламжлалт биечилсэн оролцоог цахим хэлбэртэй уялдуулах зарчим бөгөөд Бразилын “Brasil Participativo” платформд онлайн бүртгэлтэй иргэдийг бодлогын зөвлөлдөх уулзалт, үндэсний чуулганд биечлэн оролцох төлөөлөгчөөр сонгох, Исландын “Better Reykjavík”, Испанийн “Decidim.barcelona” платформуудад танхимын уулзалт, хорооллын зөвлөл, нийтийн сонсголын үр дүнг цахим платформд системтэй оруулж, цаашдын хэлэлцүүлэг, санал хураалттай уялдуулах, Энэтхэгийн “MyGov” платформ дээр онлайн даалгавар нь сайн дурын үйл ажиллагаатай (ой мод тарих, орчны цэвэрлэгээ гэх мэт) холбогдох зэрэг жишээнээс тодорхой харагдаж байна. Энэ нь цахимаар хамрагдах боломжгүй хүн амын тодорхой хэсгийг орхигдуулахгүй, цахим болон биечилсэн оролцоог харилцан нөхөх, өргөн хүрээний, хүртээмжтэй ардчиллыг дэмжих холимог оролцооны хэрэгсэл болсон сайн туршлагад тооцогдож байна.

## 2.2. Хэрэгжүүлэгч байгууллага, зохион байгуулалт

Эдгээр иргэдийн оролцооны платформууд нь улс төр, засаглалын харилцан адилгүй нөхцөлд хөгжсөн тул хариуцан хэрэгжүүлэгч институцийн загвар, зохион байгуулалт нь ялгаатай байна.

“Brasil Participativo” нь **Бразил Улсын** Холбооны Засгийн газрын нийгмийн оролцооны албан ёсны, үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг цахим платформ бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяа Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар болон түүний дэргэдэх Нийгмийн оролцооны үндэсний удирдах газар шууд хариуцан ажиллуулдаг байна. Ерөнхийлөгч Luiz Inácio Lula da Silva иргэдийн оролцооны институцуудыг сэргээх бодлогын хүрээнд 2023 онд тус платформыг “Decidim” нээлттэй эхийн програмд суурилан шинэчилж, холбооны түвшний бодлого боловсруулах үйл явц, ялангуяа 2024–2027 оны хөгжлийн төлөвлөгөөг (Plano Plurianual Participativo) иргэдийн өргөн оролцоотой боловсруулах үндсэн цахим сувгаар ашигласан байна. Институцийн хувьд “Brasil Participativo” нь бүх яам, агентлаг өөрийн нэрийн өмнөөс олон нийтийн хэлэлцүүлэг, санал асуулга, зөвлөлдөх үйл явцыг зарлан зохион байгуулж, иргэдийн саналыг авч боловсруулах нэгдсэн орчныг бүрдүүлдэг бөгөөд 2014 онд Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд ажиллаж байсан “Participa.br” платформоос 2023 оны “Brasil Participativo” руу шилжихдээ “Decidim” нээлттэй эхэд суурилсан, илүү тогтвортой, урт хугацааны нийгмийн оролцооны цахим дэд бүтэц болон институцлэгдсэн байна.

**Исланд Улсын** “Better Reykjavík” платформыг иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн захиргаа хамтран хэрэгжүүлдэг байна. Тус платформыг цахим ардчиллын нээлттэй эхийн шийдэл хөгжүүлдэг, ашгийн бус “Citizens Foundation” байгууллага 2010 онд санаачлан

“Your Priorities” веб программ дээр боловсруулан, олон нийтэд нээлттэй туршилтын журмаар ажиллуулсан байна. Үүний дараа Рейкьявик хотын захиргаа уг санаачилгыг албан ёсоор дэмжиж, 2011 оноос хотын иргэдийн цахим оролцооны үндсэн хэрэгсэл, албан ёсны оролцооны портал болгон ажиллуулж эхэлжээ (OECD, Observatory of Public Sector Innovation, n.d.).

Хотын захиргааны зүгээс платформыг институцийн түвшинд дэмжих зорилгоор мэдээллийн технологийн дэд бүтэц, хүний нөөцөөр ханган ажиллуулж, сар бүр “Better Reykjavík” дээрх иргэдийн хамгийн олон дэмжлэг авсан саналуудыг тогтмол Хотын зөвлөлийн түвшинд хэлэлцэх журам тогтоосон байна. Үүний зэрэгцээ жил бүрийн оролцооны төсөвт тогтмол хөрөнгө (тухайлбал, “Миний амьдрах орчин” хөтөлбөрт 450 сая орчим Исланд крон буюу нийт хөрөнгө оруулалтын төсвийн 6 орчим хувийг) тусгаж, дүүрэг, хорооллуудын хөрөнгө оруулалтын төслүүдийг иргэдийн саналд тулгуурлан шийдвэрлэдэг байна (“Better Reykjavík”, 2025).

Рейкьявикийн энэхүү туршлага нь иргэний нийгмийн жижиг байгууллагаас эхэлсэн санаачилгыг орон нутгийн захиргаа институцийн түвшинд хүлээн авч, албан ёсны бодлого, шийдвэрийн механизмтай уялдуулан хөгжүүлснээр цахим ардчиллын тогтолцоог амжилттай төлөвшүүлж байгаа туршлага болсон байна.

**Испани Улсын** Барселона хотын захиргааны Иргэний оролцоо, ардчиллын инновацийн газрын санаачилгаар 2016 онд “Decidim.barcelona” платформыг хотын иргэдийн оролцоог институцийн түвшинд хангах үндсэн цахим суваг болгон боловсруулсан байна (Barcelona, 2025). Хотын захиргааны ажлын алба, салбар хэлтэс, үйлчилгээний байгууллагууд, дүүргийн захиргаа болон иргэдийн оролцооны зөвлөлүүд бүгд “Decidim.barcelona” платформ дотор оролцооны хуудсаа (participatory space) нээж, түүгээрээ дамжуулан иргэдтэй хэлэлцүүлэг явуулах, санал авах, санал хураалт зохион байгуулахын зэрэгцээ биечилсэн уулзалт, зөвлөлдөх хуралдааныг цахим оролцоотой уялдуулах байдлаар ашиглаж байна. Ингэснээр “Decidim.barcelona” нь Барселона хотын захиргааны албан ёсны иргэний оролцооны дижитал бүтэц байхын зэрэгцээ, олон модульт, онлайн ба оффлайн оролцоог хослуулсан орчин үеийн цахим ардчиллын экосистем болж, хотын иргэд бодлого, төлөвлөлт, төсөв, институцийн үйл ажиллагаанд системтэй, ил тод, дагаж мөрдөхүйц байдлаар оролцох боломжийг бүрдүүлж байна.

**Энэтхэг Улсын** “MyGov” платформ нь Засгийн газрын хэмжээнд, яамд болон агентлагуудын хамтын оролцоотойгоор хэрэгждэг (Government of India, 2025). Тус платформыг Электроник, мэдээллийн технологийн яамны харьяа Үндэсний мэдээллийн төв хариуцан ажиллуулдаг бөгөөд техникийн үйлчилгээг үзүүлж, системийн тасралтгүй ажиллагааг зохион байгуулдаг байна. “MyGov” платформын үйл ажиллагааны контентыг Засгийн газрын бүх яамд, агентлагууд нийлүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, Энэтхэгийн бараг бүх яам, мөн муж улс, холбооны нутаг дэвсгэрүүдийн засаг захиргааг багтаасан 100 гаруй төрийн байгууллага “MyGov” платформ дээр өөрийн албан ёсны хуудсыг ажиллуулж, иргэдтэй харилцах, зөвлөмж, санал хүлээн авах, төрөл бүрийн сэдвээр хэлэлцүүлэг, санал асуулга, уралдаан зэрэг оролцооны үйл ажиллагааг тогтмол зарлан явуулдаг үндсэн сувгуудын нэг болгон ашиглаж байна. Түүнчлэн тус платформ нь үндэсний түвшний “MyGov” платформоос гадна Энэтхэгийн 22 муж, нутаг дэвсгэр бүрд



зориулсан “MyGov State Instance” дэд порталуудыг ажиллуулж эхэлжээ. Энэ нь тухайн муж улсын иргэд зөвхөн өөрсдийн орон нутгийн түвшний асуудал, бодлогод чиглэсэн хэлэлцүүлэг, санал асуулгад оролцох, орон нутгийн удирдлагуудтайгаа шууд харилцах боломжийг нэмэгдүүлж буй хэрэг юм. Эдгээр 22 тусдаа платформыг үндэсний “MyGov” платформтой адил бүтэцтэйгээр нэвтрүүлж, тус мужийн хэлээр мэдээлэл түгээх, санал авах ажлыг зохион байгуулж байна. Институцийн хувьд “MyGov” платформ нь Ерөнхий сайдын ажлын албаны харьяанд хэрэгждэг бөгөөд улирал тутам иргэдийн оролцооны үйл ажиллагааны гол үр дүн, гарсан санал, санаачилгыг нэгтгэн тайлагнаж, холбогдох шийдвэр гаргах түвшний байгууллагуудад хүргэдэг тогтолцоотой. “MyGov” платформын төв баг долоо хоног бүр иргэдээс ирүүлсэн ойролцоогоор 10,000 орчим саналыг ангилан шинжилж, холбогдох яам, агентлагуудад бодлого, зохион байгуулалтын шийдвэрт ашиглах боломжтой зөвлөмж хэлбэрээр дамжуулдаг байна.

Хэрэгжүүлэгч байгууллагын түвшин, институцийн загвар харилцан адилгүй боловч эдгээр платформыг амжилттай хэрэгжүүлэхэд улс төрийн шийдвэр, албан ёсны бодлогын дэмжлэг нийтлэг, шийдвэрлэх ач холбогдолтой байна. Бразил болон Энэтхэг улсын хувьд холбооны болон төв засгийн газрын гол институцууд тэргүүлэн, бүх яам, агентлагийг хамарсан үндэсний хэмжээний цахим дэд бүтцийг бий болгосон байна. Испани Улсад Барселона хотын захиргаа өөрийн нутаг дэвсгэр дээр шинэлэг платформ туршиж, нээлттэй эхийн хэлбэрээр олон хот, улс орон руу түгээн дэлгэрүүлсэн байна. Харин Исланд Улсын “Better Reykjavík” платформ нь иргэний нийгмийн байгууллага болон нийслэл хотын захиргааны түншлэлд суурилсан, албан ёсны бодлого, шийдвэрийн механизмтай уялдуулан институцчилсан онцгой туршлага болжээ.

### 2.3. Иргэдийн оролцооны үр дүн, нөлөөлөл, хүртээмжийн түвшин

Судалгааны энэ хэсэгт Бразилын “Brasil Participativo”, Исландын “Better Reykjavík”, Испанийн Барселона хотын “Decidim.barcelona”, Энэтхэгийн “MyGov” иргэдийн оролцооны платформын жишээн дээр тулгуурлан иргэдийн цахим оролцооны хэмжээ, бодлого шийдвэрт нөлөөлж буй үр дүн, хүртээмжийн түвшнийг авч үзлээ.

**Бразил** Улс нь “Brasil Participativo” платформыг ашиглан 2023 онд Холбооны Засгийн газрын “2024–2027 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулахад иргэдээс санал авсан байна. Иргэдээс 8,254 санал ирүүлж, эдгээр саналыг тойрсон 4 сая гаруй хандалт, 1.5 сая оролцоо (санал өгөх, үнэлэх, хэлэлцэх зэрэг үйлдэл) бүртгэгдсэн бөгөөд тухайн саналуудын 76.5 хувийг (58% нь бүрэн, 14% нь хэсэгчлэн) тус хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Ингэснээр “Brasil Participativo” цахим платформ богино хугацаанд улсын хөгжлийн бодлого боловсруулалтын өргөн хүрээний иргэний оролцоог бий болгожээ (Ministry of Planning and Budget, 2025).

Иргэдийн дуу хоолой улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусахын зэрэгцээ тухайн улсын нийгмийн тулгамдсан асуудлуудын эрэмбэ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж байна. Тухайлбал, 2023 оны санал асуулгаар Бразилчуудын хамгийн их санал өгсөн тэргүүлэх гурван чиглэл нь ядуурлын эсрэг тэмцэл, хүнсний аюулгүй байдал, ой мод сүйтгэлтэй тэмцэх асуудлууд байв.

**Исланд Улсын** “Better Reykjavík” платформ нь 120,000 хүн амтай Рейкьявик хотын иргэдийн тал хувийг хамарсан идэвхтэй оролцооны талбар болсон байна. 2010 онд нээгдсэнээс хойш нийт 70,000 гаруй хүн уг платформыг ашиглаж, 20,000 орчим нь албан ёсоор бүртгүүлэн идэвхтэй хэрэглэгч болжээ. Иргэдээс 6,800 гаруй санал ирүүлж, тэдгээр саналуудад 15,000 гаруй дэмжсэн болон эсрэг санал өгч, хэлэлцсэн байна. Эдгээр санаачилгаас 2011 оноос хойш 3,000 гаруйг нь хотын мэргэжлийн нэгжүүд нягтлан хэлэлцэж, ойролцоогоор 1,000 орчмыг нь “хэрэгжүүлэх санал”-ын статустайгаар баталж, бодит ажил, төсөл болгон хэрэгжүүлэх шийдвэр гаргажээ (Council of Europe, n.d.).

“Миний амьдрах орчин” оролцооны төсвийн хөтөлбөрөөр дамжуулан Рейкьявик хот 2011 оноос хойш жил бүр ойролцоогоор 450 сая Исланд крон (ойролцоогоор 3 сая евро)-ыг дүүрэг тус бүрийн иргэдийн саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөлд хуваарилж ирсэн байна. Энэ хүрээнд 2012–2017 оны хооронд 608 иргэний санаачилгыг санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна. Энэ хөтөлбөр нь хотын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоонд иргэдийн саналыг эрэмбэлэн, системтэйгээр тусгадаг үндсэн механизм болж, цахим санал хураалт, оршин суугчдын хурал, уулзалт, танхимын хэлэлцүүлгийг “Better Reykjavík” платформтой уялдуулан хэрэгжүүлдгээрээ онцлог юм.

2017 оны 07-р сарын байдлаар **Испани Улсын** Барселона хотын “Decidim.barcelona” платформд 26,700 оролцогч бүртгүүлж, 12 оролцооны үйл явцын хүрээнд 11,873 санал, санаачилга, 19,126 тайлбар (коммент), 185,783 дэмжлэг (supports) бүртгэгдэж, эдгээрээс 1,678-ыг нь бодит үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан гэж “Decidim”-ийн хөгжүүлэгчдийн нийтлэлд дурдсан нь платформ богино хугацаанд хотын түвшний том хэмжээний оролцооны дэд бүтэц болж төлөвшсөнийг харуулж байна (Xabier E. Barandiaran et al., 2017).

2016–2019 оны Хотын үйл ажиллагааны төлөвлөгөө (Municipal Action Plan, PAM) боловсруулах оролцооны үйл явцыг “Decidim.barcelona” платформоор зохион байгуулах үеэр нийт 39,429 хүн оролцсон бөгөөд үүний 4,335 нь танхимын уулзалтад оролцсон иргэд, 2,959 нь байгууллага, 32,135 нь цахим оролцогч байсан бөгөөд нийтдээ 10,860 санал, санаачилга, 18,196 тайлбар, 165,121 “дэмжлэг” бүртгэгдэж, тэдгээрээс 1,467 саналыг бодитоор хэрэгжүүлэх арга хэмжээнд тооцон, Хотын болон дүүргийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. Ингэснээр иргэдийн оруулсан саналуудын ойролцоогоор 72 хувь нь ямар нэг хэмжээгээр эцсийн төлөвлөгөөнд шингэсэн гэж Барселона хотын захиргаа тайлагнасан байна (Barcelona administration, n.d.).

2020–2021 онд Барселона хотын анхны том хэмжээний оролцоот төсөвлөлт (Participatory Budgeting 2020–2023)-ийг “Decidim.barcelona” платформоор дамжуулан хэрэгжүүлэхэд иргэд 1,982 төслийн санал ирүүлснээс 823 саналыг техникийн үнэлгээгээр хүчин төгөлдөр гэж үзэн, эцэст нь 76 төсөл сонгон, иргэдийн өгсөн санал дээр үндэслэн нийт 30 сая еврог 10 дүүрэгт хуваарилсан байна. Энэ үйл явцад онлайн ба оффлайн нийлээд нийт 73,490 оролцоо (20,772 нь биечилсэн, 52,718 нь “Decidim.barcelona”-аар дамжсан) бүртгэгдсэн, эцсийн саналт хураалтад 39,433 иргэн оролцсон байна (Time use initiative, 2025).

Хүртээмжийн хувьд “Decidim.barcelona” нь хотын хэмжээний стратеги төлөвлөгөө, оролцоот төсөвлөлт, дүүрэг бүрийн хөгжлийн төлөвлөгөө болон салбар бодлогын (орчны

төлөвлөлт, ногоон хөгжил, нийгмийн үйлчилгээ, соёл урлаг гэх мэт) гол үйл явцыг нэг дор төвлөрүүлж, тус бүрд нь оролцооны орон зай (participatory space) цахим хуудас нээж ажиллуулдаг. Оролцооны орон зайд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, дүүргийн зөвлөл зэрэг оролцогч талууд тогтмол оролцож, санал гаргах, хэлэлцэх, дэмжлэг өгөх, төслийг эрэмбэлэх зэрэг процессыг цахимаар хэрэгжүүлдэг байна. Нөгөө талаас эдгээр онлайн үйл явц нь хөршийн зөвлөлийн хурал, танхимын уулзалт, иргэдийн зөвлөл зэрэг биечилсэн хэлбэрийн оролцоотой уялдсан байдлаар явдаг бөгөөд нүүр тулсан уулзалтын зар, бүртгэл, тэмдэглэл, гарсан санал, шийдвэрийг платформ дээр давхар нийтэлснээр онлайн ба оффлайн оролцоо нэгэн цогц процессын хүрээнд холбогдон, ил тод, дагаж мөрдөхүйц бүртгэлтэй болох зохицуулалттай байна (Decidim docs, n.d.).

**Энэтхэг Улсын “MyGov” платформ нь хэрэглэгч, оролцогчдын тоогоор дэлхийн хамгийн том цахим оролцооны системд тооцогдож байна.** 2025 оны байдлаар ойролцоогоор 60.3 сая хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд иргэд нийтдээ 1.8 сая гаруй даалгавар, сайн дурын ажил, онлайн болон оффлайн ажилд оролцсон тайлан ирүүлж, хэлэлцүүлгүүдэд 5.6 сая орчим сэтгэгдэл үлдээж, санал асуулгад 3.9 сая орчим санал өгч, асуулт–хариултын онлайн сорилуудад 31.1 сая гаруй удаа оролцсон байна. Мөн 164 өөр дэмжлэг, амлалтын аянд нийлээд 25.6 сая хэрэглэгч нэгдэж, ойролцоогоор 25.6 сая удаа цахим тангараг өргөсөн гэж тус платформын нүүр хуудаснаа нэгтгэн мэдээлжээ (Government of India, 2025).

Боловсролын шинэ бодлогын төслийг боловсруулахад 2015 онд “MyGov” платформоор 29,000 гаруй санал, санаачилга хүлээн авсныг Энэтхэг Улсын Хүний нөөцийн хөгжлийн яам нэгтгэн, бодлогын баримт бичигт тусгасан байна (Ministry of Human Resource Development, n.d.).

Оролцогчдын хамрах хүрээ өргөн буюу насны хувьд 20-40 насныхан зонхилох боловч ахмад болон өсвөр үеийнхэн, үндэсний хэмжээнд хот, хөдөө бүхий л газраас хандах боломжтой.

“MyGov” платформыг Энэтхэг Улсын Засгийн газар нийгмийн олонхын санаа бодлыг тандах, томоохон шийдвэрийн өмнө иргэдээ бэлтгэх сувгаар ашиглах тохиолдол ч байдаг байна. Тухайлбал, 2016 онд Энэтхэг Улс төлбөрийн хэрэгслээ шинэчлэх (“demonetization”) шийдвэрийн өмнө “MyGov” платформ дээр иргэдийн дунд бэлэн мөнгөний хэрэглээ, цахим төлбөрийн тухай санал асуулга явуулж, сая гаруй хүн оролцон 93% нь цахим төлбөр тооцоог дэмжиж буйгаа илэрхийлсэн нь олон нийтэд энэ шийдвэрийг эерэг хүлээж авах хөрс бий болгосон гэж үздэг байна (rediff, n.d.).

“MyGov” платформд иргэдээс олон сая санал, санаачилга тасралтгүй ирүүлдэг хэдий ч тэдгээрийг Засгийн газар бодлого, шийдвэр гаргах түвшинд бүрэн, системтэй ашиглахгүй байгаа, харин тодорхой хэмжээнд мэдээлэл түгээх нэг талын суваг болгон ашиглаж байна гэсэн шүүмжлэл гардаг байна. Ялангуяа “MyGov” платформын форум дахь олон тооны санал, асуултад холбогдох байгууллагаас албан ёсны хариу өгдөггүй, эсвэл иргэд саналаа өгсөн ч тухайн санал нь бодит шийдвэрт хэрхэн нөлөөлснийг хянах ил тод механизм дутмаг байгааг иргэдийн зүгээс шүүмжилдэг байна. Ийм байдлаар асар их хэмжээний санал, өгөгдөл хуримтлагдаж байгаа нь нэг талаас платформын хүрээг харуулж буй ч, нөгөө талаас тэдгээрийг ангилан боловсруулах чадавх, иргэдэд буцаан мэдээлэх, аль саналыг хүлээн авч, алийг нь ямар шалтгаанаар хэрэгжүүлээгүйг тайлбарлах хариу

үйлдлийн тогтолцоонд өндөр шаардлага тавьж байгаа бөгөөд цаашид энэ чиглэлийн институцийн механизм, дотоод зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна (Manazir, 2023).

Дээрх платформууд нь улс, хотын түвшинд (үндэсний хөгжлийн төлөвлөгөө, хотын үйл ажиллагааны төлөвлөгөө, оролцоот төсөвлөлт, салбарын бодлого, боловсролын шинэчлэл зэрэг) иргэдийн саналыг системтэйгээр оруулж, тоон мэдээллээр нотлогдохуйц бодит үр дүн гаргаж эхэлсэн нь цахим оролцоог албан ёсны шийдвэр гаргалтын салшгүй бүрэлдэхүүн болж буйг харуулж байна. Тухайлбал, Бразилын “Brasil Participativo” платформуор дамжуулан иргэдийг улс орны “2024–2027 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний үндсэн зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход шууд оролцуулж, хөгжлийн бодлогоо цахим зөвлөлдөх үйл явцаар бүрдүүлсэн бол Исландын “Better Reykjavík” нь хотын түвшинд дүүрэг, хорооллуудын өдөр тутмын амьдралд нөлөөлөх жижиг хэмжээний бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийг (орон сууцны орчны сайжруулалт, зам, тоглоомын талбай, нийтийн үйлчилгээ гэх мэт) иргэдийн саналд тулгуурлан шийдвэрлэдэг оролцооны төсвийн тогтолцоо болгон төлөвшсөн байна. Барселона хотын “Decidim.barcelona” нь нэг талаас “Хотын үйл ажиллагааны төлөвлөгөө” болон оролцооны төсөв зэрэг стратегийн баримт бичиг, хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийг, нөгөө талаас орчны төлөвлөлт, ногоон бодлого, нийгмийн үйлчилгээ, соёлын бодлого зэрэг салбар бүрийн оролцооны үйл явцыг нэг дор нэгтгэсэн, онлайн ба танхимын хэлбэрийг уялдуулсан иж бүрэн оролцооны систем болж хөгжжээ. Харин Энэтхэгийн “MyGov” платформ нь боловсролын шинэ бодлого, татварын шинэчлэл зэрэг салбарын реформуудаас эхлээд үндэсний хэмжээний кампанит ажлуудын нэр, лого, уриаг сонгох, мөн төлбөрийн хэрэгслийн шинэчлэл (“demonetization”) зэрэг үндэсний хэмжээний томоохон шийдвэрийн өмнөх олон нийтийн хандлагыг тандах хүртэл маш өргөн хүрээнд зөвлөлдөх, санал авах суваг болон ашиглагдаж буйгаараа онцлогтой байна.

**Хүснэгт 1. Иргэдийн оролцооны платформын хамрах хүрээ, үр дүн, нөлөөлөл**

| Улс/<br>Платформын<br>нэр        | Бразил<br>“Brasil Participativo”                                                                                                                                                                                        | Энэтхэг<br>“MyGov”                                                                                                                                                                                  | Исланд<br>“Better Reykjavík”                                                                                                                                                                                     | Испани (Барселона)<br>“Decidim.barcelona”                                                                                                                                                                                                                   |
|----------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                  | (Үндэсний)                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                     | (Орон нутгийн/хотын)                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                             |
| Нэвтрүүлсэн<br>он, нөхцөл        | 2023 онд Ерөнхийлөгчийн ажлын албанаас иргэдийн оролцооны институцуудыг сэргээх, 2024–2027 оны хөгжлийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулах зорилготой “Decidim” нээлттэй эхэд суурилан, шинэчилж нэвтрүүлсэн. | 2014 онд Энэтхэгийн Засгийн газар “иргэдийг бодлого, шийдвэр гаргалтад өргөн оролцуулах, сайн засаглалыг төлөвшүүлэх” зорилготой нэвтрүүлсэн.                                                       | 2010 онд “Citizens Foundation” ТББ, Рейкьявик хотын захиргаа хамтран цахим ардчиллын туршилтын санаачилга хэлбэрээр нэвтрүүлсэн.                                                                                 | 2016 онд Барселона хотын Иргэний оролцоо, ардчиллын инновацийн газрын санаачилгаар, 2016–2019 оны Хотын үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулах эхний зорилгоор нэвтрүүлж, дараа нь нээлттэй эхийн “Decidim” хүрээ болгон өргөжүүлсэн. |
| Түвшин,<br>хамрах хүрээ          | Үндэсний түвшинд Холбооны Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөө, салбар бодлогын хэлэлцүүлэг (эрүүл мэнд, байгаль орчин, дэд бүтэц)                                                                                        | Үндэсний болон мужийн түвшинд Холбооны Засгийн газар, бүх яам, агентлаг болон 22 мужийг хамарсан. Муж бүр “MyGov State” дэд платформтой.                                                            | Хот - орон нутгийн түвшинд 120,000 хүн амтай Рейкьявик хотын бүх дүүрэг, хорооллыг хамарсан.                                                                                                                     | Хот - орон нутгийн түвшинд Барселона хотын бүх дүүрэг, хорооллыг хамарсан.                                                                                                                                                                                  |
| Хэрэгжүүлэгч<br>байгууллага      | Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяа Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар болон түүний дэргэдэх Нийгмийн оролцооны үндэсний удирдах газар шууд хариуцан ажиллуулдаг.                                                 | Электроник, мэдээллийн технологийн яамны харьяа Үндэсний мэдээллийн төв хариуцан ажиллуулдаг. “MyGov” платформын үйл ажиллагааны контентыг Засгийн газрын бүх яамд, агентлагууд нийлүүлэх үүрэгтэй. | “Citizens Foundation” ашгийн бус байгууллага программ хангамж, хөгжүүлэлтийг хариуцаж, Рейкьявик хотын захиргаа платформын албан хэрэгжилт, төсөв, институцийн дэмжлэгийг хангадаг.                              | Барселона хотын захиргаа, Иргэний оролцоо ба Ардчиллын инновацийн газар платформын бодлого, хэрэгжилтийг хариуцаж, “Decidim Association” нь нээлттэй эхийн хөгжүүлэлт, олон улсын хамтын ажиллагааг удирддаг.                                               |
| Үндсэн<br>оролцооны<br>хэлбэрүүд | Онлайн хэлэлцүүлэг; санал хураалт; бодлогын санал, санаачилга; олон нийтийн зөвлөлдөх ажиллагаа; оффлайн уулзалтад бүртгүүлэх; цахимаар сонгогдсон төлөөлөгч үндэсний зөвлөлдөх чуулганд оролцох боломж.                | Хэлэлцүүлэг, даалгавар/сайн дурын ажил, санал асуулга, судалгаа, онлайн уулзалт, инновацийн уралдаан, асуулт–хариултын сорил, тангараг/амлалтын аян.                                                | Асуудал дэвшүүлэх, хэлэлцэх; оролцооны төсөв (“Better Neighborhoods”); бодлого боловсруулах; онлайн мэтгэлцээн; цахим санал хураалт; онлайн оролцоог хөршийн зөвлөлийн хурал, танхимын хэлэлцүүлэгтэй уялдуулах. | Оролцооны үйл явц (Хотын үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, дүрэм журам); иргэдийн санал, санаачилга (дэмжлэгийн босготой); хэлэлцүүлэг, мэтгэлцээн; оролцооны төсөв; Онлайн ба оффлайн оролцоог нэгтгэх.                                                |

|                                                |                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Оролцооны<br>цар хүрээ,<br>тоон<br>үзүүлэлтүүд | Холбооны ЗГ-ын 2024–2027 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад 8,254 санал, тэдгээрийг тойрсон 4 сая гаруй хандалт, 1.5 сая оролцоо (санал өгөх, үнэлэх, хэлэлцэх үйлдэл) бүртгэгдсэн.                             | 2025 оны байдлаар 60.3 сая бүртгэлтэй хэрэглэгч; 1.8 сая даалгавар, сайн дурын ажил, онлайн/офлайн ажилд оролцсон тайлан; 5.6 сая сэтгэгдэл; 3.9 сая орчим санал; 31.1 сая гаруй онлайн сорилын оролцоо; 25.6 сая удаа цахим тангараг өргөсөн.                                                                                | 70,000 гаруй иргэд платформ ашигласнаас 20,000 нь бүртгэлтэй, идэвхтэй хэрэглэгч; 6,800+ санал, 15,000+ дэмжсэн/эсрэг санал ирүүлсэн. 2011 оноос жил бүр “Миний амьдрах орчин” оролцооны төсөвт санал авч, 2012–2017 онд 608 санаачилга санхүүжүүлсэн.                            | 2017 оны 07-р сарын байдлаар “Decidim.barcelona”-д 26,700 оролцогч бүртгүүлж, 11,873 санал, санаачилга, 19,126 тайлбар (коммент), 185,783 дэмжлэг (supports) бүртгэгдэж, эдгээрээс 1,678-ыг нь бодит үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. 2016–2019 Хотын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 39,429 оролцогч, 10,860 санал, 18,196 тайлбар, 165,121 дэмжлэг ирүүлснээс 1,467 саналыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Онлайн ба офлайн нийлээд нийт 73,490 оролцоо (20,772 нь биечилсэн, 52,718 нь платформоор дамжсан), эцсийн саналт хураалтад 39,433 иргэн оролцсон. |
| Бодит үр дүн,<br>нөлөөлөл                      | 2024–2027 оны үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд иргэдийн саналын 76.5% (58% бүрэн, 14% хэсэгчлэн) тусгагдсан; үндэсний хөгжлийн бодлогын зорилт, тэргүүлэх чиглэлийг иргэдийн оролцоотой тодорхойлох гол суваг болсон. | Төрийн бодлого, хуулийн төслүүдэд иргэдийн саналыг авах нийтлэг жишиг тогтсон. (NEP, Data Protection Bill гэх мэт олон баримт бичигт MyGov-д ирсэн саналуудыг тусгасан). Үндэсний хэмжээний олон кампанит ажил (Clean India, Digital India) иргэдийн оролцоотой хэрэгжсэн. Иргэдийн төрд итгэх итгэлд эерэг нөлөө бий болсон. | 2011 оноос хойш 3,000 гаруй саналыг мэргэжлийн нэгжүүд нягталж, 1,000 орчмыг нь “хэрэгжүүлэх санал” болгон баталж, бодит төсөл болгосон; хотын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн гол оролцооны механизм болсон; “Таны үнэт зүйл” программ бусад улс оронд хуулбарлан ашиглаж байна. | Стратеги төлөвлөгөө, оролцооны төсөв, дүрэм журам, салбарын бодлогод иргэдийн оролцоог институцийн түвшинд тогтворжуулсан; “Decidim” нээлттэй эхийн программ Европ, Америк тивийн олон хот, байгууллагад хуулбарлан ашиглаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамруулсан улс орнуудын иргэдийн оролцооны (Бразилын “Brasil Participativo”, Энэтхэгийн “MyGov”, Исландын “Better Reykjavík”, Испанийн Барселона хотын “Decidim.barcelona”) платформууд нь зорилго, оролцооны хэлбэрийн хувьд харилцан адилгүй боловч нийтлэгээр иргэдийн шууд оролцоог институцийн түвшинд нэмэгдүүлж, бодлого боловсруулах, төсөв хэлэлцэх, хуваарилах, хот төлөвлөлт, салбарын реформ зэрэгт иргэдийн санал, санаачилгыг системтэй шингээхэд чиглэж байна. Бразил болон Энэтхэг улсын платформууд үндэсний хэмжээний хөгжлийн төлөвлөгөө, салбарын бодлогын төсөл (тухайлбал, “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 2024–2027”, Боловсролын шинэ бодлого, татварын шинэчлэл) дээр өргөн цар хүрээтэй цахим зөвлөлдөх, санал авах процессыг бүрдүүлсэн бол Исландын Рейкьявикийн “Better Reykjavík”, Испанийн Барселонагийн “Decidim.barcelona” нь хотын түвшинд оролцооны төсөв, хотын үйл ажиллагааны төлөвлөгөө, орчны төлөвлөлт, ногоон бодлого, нийгмийн үйлчилгээ, соёлын бодлого зэрэг өдөр тутмын шийдвэр гаргалттай иргэдийн оролцоог уялдуулсан орон нутгийн цахим ардчиллын систем болж төлөвшжээ.

Судалгаанд хамрагдсан Бразилын “Brasil Participativo”, Исландын “Better Reykjavík”, Испанийн Барселона хотын “Decidim.barcelona” платформууд нь онлайн хэлэлцүүлэг, цахим санал асуулга, иргэний санаачилга, оролцооны төсвийг танхимын уулзалт, хөршийн зөвлөлийн хуралдаан, нийтийн сонсгол зэрэг биечилсэн хэлбэрүүдтэй уялдуулсан шат дараалсан, ил тод оролцооны процесс бүрдүүлсэн бол Энэтхэгийн “MyGov” платформ нь голчлон цахим оролцоонд тулгуурлаж, тодорхой модулиараа сайн дурын оффлайн үйл ажиллагаатай холбогдсон онцлогтой байна.

Иргэдийн цахим оролцооны хэрэгжилтийг хангах институц, засаглалын зохион байгуулалтын хувьд Бразил Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Энэтхэгийн Ерөнхий сайдын ажлын алба, Үндэсний мэдээллийн төв зэрэг төв байгууллагууд үндэсний түвшний платформыг санаачлан хөгжүүлж, бүх яам, агентлаг, муж улсыг нэг дэд бүтцэд холбосон байна. Харин Барселона хотын “Decidim.barcelona” платформыг Хотын захиргааны Иргэний оролцоо, ардчиллын инновацын газраас удирдан, зохион байгуулж, “Decidim Association” нээлттэй эхийн хөгжүүлэлт, олон улсын сүлжээг удирдан, орон нутагт төвтэй, экспортлогдох загварыг хөгжүүлжээ. Харин Исланд Улсын Рейкьявик хотын “Better Reykjavík” платформ нь “Citizens Foundation” иргэний нийгмийн байгууллага болон хотын захиргааны түншлэлийн хэлбэрээр хөгжсөнөөрөө онцлогтой байна. Эдгээр жишээнээс харахад платформын тогтвортой хэрэгжилтийн суурь нөхцөл нь улс төрийн манлайлал, албан ёсны бодлого, эрх зүйн дэмжлэг, платформыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, төлөвлөлтийн мөчлөгтэй институцийн хувьд уялдуулах зэрэг үйл явц болохыг харуулж байна.

Эдгээр платформууд нь иргэдийн оролцооны тоо хэмжээ, төрөл хэлбэрийг эрс нэмэгдүүлж, бодлого шийдвэрт тоон утгаар нотлогдохуйц үр нөлөө үзүүлж байна. Бразилд “Brasil Participativo” платформоор цугларсан 8,254 саналаас 76.5 хувь нь “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 2024–2027”-д бүрэн буюу хэсэгчлэн тусгагдсан нь үндэсний хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлийг иргэдийн оролцоотой тодорхойлсон тод жишээ юм. Исланд Улсын Рейкьявикт “Better Reykjavík” платформоор дамжин 3,000 гаруй санал мэргэжлийн үнэлгээгээр хэлэлцэгдэж, 1,000 орчим нь “хэрэгжүүлэх санал” болж, “Миний амьдрах орчин”

оролцооны төсвөөр дамжин 600 гаруй санаачилга санхүүжигдсэн нь хотын дэд бүтэц, нийтийн орон зайн сайжруулалтад бодит, хэмжигдэхүйц үр дүн бий болгожээ. Барселона хотын “Decidim.barcelona” платформ нь “Хотын үйл ажиллагааны төлөвлөгөө” болон оролцооны төсөвт ирсэн саналуудын ойролцоогоор 72 хувийг тодорхой хэмжээгээр төлөвлөгөөнд оруулж, стратеги төлөвлөгөө, дүрэм журам, салбарын бодлогод иргэдийн оролцоог институцийн түвшинд байнгын оролцоотой болгосон байна.

Испани Улсын нээлттэй эхийн “Decidim” программыг Европ болон Америк тивийн олон хот, байгууллагад хуулбарлан ашиглаж буй бол Исланд Улсын “Citizens Foundation”-ийн боловсруулсан “Your Priorities” нээлттэй эхийн программыг Исланд болон олон улсад бодлогын зөвлөлдөх, төсвийн оролцооны төсөлд өргөнөөр ашиглаж байна.

Энэтхэгийн “MyGov” платформ нь хэрэглэгчийн тоо, оролцооны давтамжаар дэлхийн хамгийн том платформ болж, боловсролын шинэ бодлого, татварын шинэчлэл зэрэгт олон арван мянган санал нэгтгэж, мөн үндэсний хэмжээний кампанит ажилд иргэдийн улс төр-нийгмийн оролцоог идэвхжүүлж байгаа боловч, нөгөө талаас иргэдийн асар олон саналд төрөөс өгөх эргэх хариу, бодит нөлөөллийг тайлагнах механизм дутмаг байгаа нь урт хугацаанд платформын хууль ёсны байдал, итгэлцэлд эрсдэл дагуулж болзошгүй сул тал үүссэн байна.



## НОМ ЗҮЙ

- OECD . (2022). *OECD Guidelines for Citizen Participation Processes*. From OECD: [https://www.oecd.org/en/publications/oecd-guidelines-for-citizen-participation-processes\\_f765caf6-en.html?utm\\_source](https://www.oecd.org/en/publications/oecd-guidelines-for-citizen-participation-processes_f765caf6-en.html?utm_source)
- OECD. (2022). *Working Party on Open Government*. From OECD: [https://one.oecd.org/document/GOV/PGC/OG%282020%294/FINAL/en/pdf?utm\\_source](https://one.oecd.org/document/GOV/PGC/OG%282020%294/FINAL/en/pdf?utm_source)
- UN. (2025). *SDG Goals-Indicators*. From UN: [https://unstats.un.org/sdgs/metadata/?Goal=16&Target=16.7&utm\\_source](https://unstats.un.org/sdgs/metadata/?Goal=16&Target=16.7&utm_source)
- OECD. (2024). *Survey on Drivers of Trust in Public Institutions-2024 Results*. From OECD: [https://www.oecd.org/en/publications/oecd-survey-on-drivers-of-trust-in-public-institutions-2024-results\\_9a20554b-en.html](https://www.oecd.org/en/publications/oecd-survey-on-drivers-of-trust-in-public-institutions-2024-results_9a20554b-en.html)
- OECD. (2022). *OECD Guidelines for Citizen Participation Processes* . From OECD: [https://www.oecd.org/en/publications/oecd-guidelines-for-citizen-participation-processes\\_f765caf6-en.html?utm\\_source](https://www.oecd.org/en/publications/oecd-guidelines-for-citizen-participation-processes_f765caf6-en.html?utm_source)
- UNDP. (2018). *WHAT DOES IT MEAN TO LEAVE NO ONE BEHIND?* From UNDP: [https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/publications/Discussion\\_Paper\\_LNOB\\_EN\\_lres.pdf?utm\\_source](https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/publications/Discussion_Paper_LNOB_EN_lres.pdf?utm_source)
- World Bank Group. (2025). *Civic and Citizen Engagement*. From World Bank Group: [https://www.worldbank.org/en/topic/citizen-engagement?utm\\_source](https://www.worldbank.org/en/topic/citizen-engagement?utm_source)
- OECD. (2025). *Recommendation of the Council on OECD Legal Instruments Open Government*. From OECD: <https://legalinstruments.oecd.org/public/doc/359/359.en.pdf>
- OECD. (2020). *Innovative Citizen Participation and New Democratic Institutions CATCHING THE DELIBERATIVE WAVE*. From OECD: [https://library.uniteddiversity.coop/Decision\\_Making\\_and\\_Democracy/Innovative\\_Citizen\\_Participation\\_and\\_New\\_Democratic\\_Institutions-Catching\\_the\\_Deliberative\\_Wave.pdf](https://library.uniteddiversity.coop/Decision_Making_and_Democracy/Innovative_Citizen_Participation_and_New_Democratic_Institutions-Catching_the_Deliberative_Wave.pdf)
- World Bank . (2013). *Localizing Development Does Participation Work?* From World Bank : <https://www.local2030.org/library/323/Localizing-development-does-participation-work-.pdf>
- NDC Partnership. (n.d.). *Strategic Framework for Mainstreaming Citizen Engagement in World Bank Group Operations*. From NDC Partnership: <https://ndcpartnership.org/knowledge-portal/climate-toolbox/strategic-framework-mainstreaming-citizen-engagement-world-bank-group-operations#:~:text=objectives%20for%20citizen%20engagement,prosperity%20in%20a%20sustainable%20manner>
- OECD. (2021). *Open government and citizen participation* . From OECD: <https://www.oecd.org/en/topics/sub-issues/open-government-and-citizen-participation.html#:~:text=Perceptions%20of%20opportunities%20to%20influence,local%20decisions%2C%202021>
- UN. (2024). *E-Government Survey 2024*. From UN: [https://www.government-transformation.com/hubfs/%28Web%20version%29%20E-Government%20Survey%202024%201392024-compressed.pdf?utm\\_source](https://www.government-transformation.com/hubfs/%28Web%20version%29%20E-Government%20Survey%202024%201392024-compressed.pdf?utm_source)
- UN. (2024). *E-Government Survey 2024*. From UN: <https://desapublications.un.org/sites/default/files/publications/2024-09/%28Web%20version%29%20E-Government%20Survey%202024%201392024.pdf>
- ResearchGate. (2020). *Participa.br*. From ResearchGate: [https://www.researchgate.net/publication/343657847\\_Participabr\\_A\\_Critical\\_Study\\_Case\\_of\\_a\\_Participatory\\_Democracy\\_Mechanism\\_based\\_on\\_a\\_Free\\_and\\_Open\\_Source\\_Software\\_from\\_Perspective\\_of\\_Actor-Network\\_Theory](https://www.researchgate.net/publication/343657847_Participabr_A_Critical_Study_Case_of_a_Participatory_Democracy_Mechanism_based_on_a_Free_and_Open_Source_Software_from_Perspective_of_Actor-Network_Theory)

Open Government Partnership. (2024). *How Brazil is widening public participation*. From Open Government Partnership: [https://www.opengovpartnership.org/brazil-digital-governance-story/?utm\\_source](https://www.opengovpartnership.org/brazil-digital-governance-story/?utm_source)

Gov.br.(2025). *Participatory Brazil*. From Gov.br: [https://brasilparticipativo.presidencia.gov.br/?utm\\_source](https://brasilparticipativo.presidencia.gov.br/?utm_source)

Democracy technologies. (2023). *Brazil's Participatory Pluriannual Plan*. From Democracy technologies: [https://democracy-technologies.org/participation/brazils-participatory-pluriannual-plan/?utm\\_source](https://democracy-technologies.org/participation/brazils-participatory-pluriannual-plan/?utm_source)

Better Reykjavik . (2025). *Better Reykjavik* . From Better Reykjavik : <https://betrireykjavik.is/domain/1>

OECD, Observatory of Public Sector Innovation. (2010). *Case Study Library, Better Reykjavik*. From OECD, Observatory of Public Sector Innovation: [https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm\\_source](https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm_source)

OECD, Observatory of Public Sector Innovation. (2010). *Better Reykjavik*. From OECD, Observatory of Public Sector Innovation: [https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm\\_source](https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm_source)

Citizens.is. (2025). *Better Reykjavík*. From Citizens.is: [https://www.citizens.is/portfolio\\_page/better\\_reykjavik/?utm\\_source](https://www.citizens.is/portfolio_page/better_reykjavik/?utm_source)

OECD, Observatory of Public Sector Innovation. (2010). *Better Reykjavik* . From OECD, Observatory of Public Sector Innovation: <https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/>

NESTA. (n.d.). *Better Reykjavik*. From NESTA: [https://www.nesta.org.uk/feature/10-people-centred-smart-city-initiatives/better-reykjavik/?utm\\_source](https://www.nesta.org.uk/feature/10-people-centred-smart-city-initiatives/better-reykjavik/?utm_source)

Reykjavik. (2023). *My Neighborhood*. From Reykjavik: [https://reykjavik.is/en/my-neighborhood?utm\\_source](https://reykjavik.is/en/my-neighborhood?utm_source)

Citizens.is. (2025). *Better Reykjavík*. From CITIZENS.IS: [https://www.citizens.is/portfolio\\_page/better\\_reykjavik/?utm\\_source](https://www.citizens.is/portfolio_page/better_reykjavik/?utm_source)

OECD, Observatory of Public Sector Innovation. (2025). *Better Reykjavik*. From OECD, Observatory of Public Sector Innovation: [https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm\\_source](https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/?utm_source)

Citizens.is. (2025). *Platforms and AI empowering citizens and governments* . From Citizens.is: [https://www.citizens.is/?utm\\_source](https://www.citizens.is/?utm_source)

Barcelona . (2025). *decidim.barcelona*. From Barcelona : [https://ajuntament.barcelona.cat/innovaciodemocratica/en/decidimbarcelona?utm\\_source](https://ajuntament.barcelona.cat/innovaciodemocratica/en/decidimbarcelona?utm_source)

UN, Department of Economic and Social Affairs. (n.d.). *Decidim: a multipurpose open source platform for e-participation*. From UN, Department of Economic and Social Affairs: [https://publicadministration.desa.un.org/good-practices-for-digital-government/compendium/decidim-multipurpose-open-source-platform-e?utm\\_source](https://publicadministration.desa.un.org/good-practices-for-digital-government/compendium/decidim-multipurpose-open-source-platform-e?utm_source)

decidim docs. (n.d.). *Decidim documentation*. From decidim docs: [https://docs.decidim.org/en/develop/understand/about.html?utm\\_source](https://docs.decidim.org/en/develop/understand/about.html?utm_source)

UN, Department of Economic and Social Affairs. (n.d.). *Decidim: a multipurpose open source platform for e-participation*. From UN, Department of Economic and Social Affairs: [https://publicadministration.desa.un.org/good-practices-for-digital-government/compendium/decidim-multipurpose-open-source-platform-e?utm\\_source](https://publicadministration.desa.un.org/good-practices-for-digital-government/compendium/decidim-multipurpose-open-source-platform-e?utm_source)

IDS. (2023). *Decidim: why digital tools for democracy need to be developed democratically*. From IDS: [https://www.ids.ac.uk/opinions/decidim-why-digital-tools-for-democracy-need-to-be-developed-democratically/?utm\\_source](https://www.ids.ac.uk/opinions/decidim-why-digital-tools-for-democracy-need-to-be-developed-democratically/?utm_source)

Impact and Policy Research Institute. (2025). *MyGov,2014: A Paradigm of Participatory Governance in India* . From Impact and Policy Research Institute: <https://www.impriindia.com/insights/mygov-participatory-governance-india/>

Educate Bee. (2023). *What is MyGov Saathi 2.0*. From Educate Bee: [https://www.educatebee.com/what-is-mygov-saathi-2-0/?utm\\_source](https://www.educatebee.com/what-is-mygov-saathi-2-0/?utm_source)

IMPRI. (2025). *MyGov,2014: A Paradigm of Participatory Governance in India* . From IMPRI: <https://www.impriindia.com/insights/mygov-participatory-governance-india/>

IGI Global. (2020). *Platform for Citizen Engagement for Good Governance in India: A Case Study of MyGov.in*. From IGI Global: <https://www.igi-global.com/chapter/platform-for-citizen-engagement-for-good-governance-in-india/250583>

decidim free open source democracy. (n.d.). *Decidim is a digital platform for citizen participation* . From decidim free open source democracy: <https://decidim.org/>

Ministry of Planning and Budget. (2025). *Cross-Cutting Territorial Agendas for the 2024-2027 Multi-Year Plan (PPA) in conjunction with Regional Development Plans*. From Ministry of Planning and Budget: <https://www.gov.br/planejamento/pt-br/assuntos/noticias/2025/agosto/governo-federal-lanca-agendas-transversais-territoriais-do-ppa-2024-2027-em-articulacao-com-planos-regionais-de-desenvolvimento>

Council of Europe. (n.d.). *Better Reykjavik*. From Council of Europe: <https://www.coe.int/en/web/interculturalcities/-/better-reykjavik>

Barcelona . (2025). *decidim.barcelona*. From Barcelona : <https://www.decidim.barcelona/>

Xabier E. Barandiaran et al.,. (2017). *Decidim: political and technopolitical networks for participatory democracy*. From <https://tecnopolitica.net/sites/default/files/08%20Xabier%2C%20Antonio%2C%20Arnau%2C%20Pablo....pdf>

Barcelona administration. (n.d.). *Decidim and the Municipal Action Plan in Barcelona*. From slideshare: <https://www.slideshare.net/slideshow/decidim-and-the-municipal-action-plan-in-barcelona-coproducing-and-auditing-public-policy-through-a-political-network-pablo-aragn-universitat-pompeu-fabra-spain-virgile-deville-open-source-politics-code-for-france-demo>

Time use initiative. (2025). *Barcelona's Participatory Budgeting*. From Time use initiative: <https://timeuse.barcelona/good-practices/barcelonas-participatory-budgeting/>

Decidim docs. (n.d.). *Participatory spaces*. From Decidim docs: <https://docs.decidim.org/en/develop/features/participatory-spaces.html>

Government of India. (2025). *MyGov*. From Government of India: <https://www.mygov.in/>

Ministry of Human Resource Development. (n.d.). *Annual Report 2017-2018*. From Ministry of Human Resource Development: [https://www.education.gov.in/sites/upload\\_files/mhrd/files/document-reports/MHRD%20AR-2017-18%20English.pdf](https://www.education.gov.in/sites/upload_files/mhrd/files/document-reports/MHRD%20AR-2017-18%20English.pdf)

rediff. (n.d.). *Over 93% for demonetisation, PM Modi's app survey reveals*. From rediff: <https://www.rediff.com/news/report/over-93-for-demonetisation-pm-modis-app-survey-reveals/20161123.htm>

OECD, Observatory of Public Sector Innovation . (n.d.). *Better Reykjavik*. From OECD, Observatory of Public Sector Innovation : <https://oecd-opsi.org/innovations/better-reykjavik/>

“Better Reykjavik”. (2025). *Better Reykjavik*. From “Better Reykjavik”: <https://betrireykjavik.is/domain/1>

Barcelona. (2025). *Decidim.barcelona*. From Barcelona: <https://www.decidim.barcelona/>

Government of India. (2025). *MyGov*. From Government of India: <https://www.mygov.in/#>